

Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 225 дугаар тогтоолоор баталсан

"Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 4 дүгээр хавсралт

2026 оны 01 дүгээр улирлын үйл ажиллагааны тайлан /маягт 2/		
Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.		
Тайлагнах хугацаа /Жишээ нь: 2020 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 3 дугаар сарын 31-ний өдөр/	2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2026 оны 03 дугаар сарын 31-ны өдөр/	
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	Улсын Их Дэлгүүр ХК УБГэрчилгээ: 9010001067 Утас:11324311 89885120	
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын хөрөнгийн бирж	
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Үл хөдлөх хөрөнгийн түрээс	
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	36.807.850 ширхэг	
Хагас жил, улирлын тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Өлзийбат Ахлах нягтлан бодогч Д.Чимгээ Гүйцэтгэх захирал Х.Эрдэнэбаатар	
1	Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/	
	Санхүүгийн байдлын үзүүлэлт	2026 оны 1-р улиралд нийт хөрөнгийн дүн 12,848.5 сая төгрөг, үүнээс эргэлтийн хөрөнгө 2.8 хувь буюу 359.3 сая төгрөг, эргэлтийн бус хөрөнгө 97.2 хувь буюу 12,489.2 сая төгрөгийг эзэлж байна. Нийт эх үүсвэр 12,848.5 сая төгрөг, үүнээс өр төлбөр 15,549.8 сая төгрөг, эзний өмч -2,701.3 сая төгрөг байна. Санхүүгийн тайланг 2026 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр хүлээлгэн өгсөн.
	Орлогын тайлан	2026 оны 1-р улиралд түрээсийн орлого 2,387.9 сая төгрөг, зардал 2,085.7 сая төгрөг, 302.2 сая төгрөгийн ашигтай ажилласан байна. Санхүүгийн тайланг 2026 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр хүлээлгэн өгсөн.
	Өмчийн өөрчлөлтийн тайлан	2026 оны 1-р улиралд 302.2 сая төгрөгийн ашигтай ажиллаж улирлын эцэст эзний өмчийн дүн -2,701.3 сая төгрөг байна. Санхүүгийн тайланг 2026 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр хүлээлгэн өгсөн.
	Мөнгөн гүйлгээний тайлан	2026 оны 1-р улиралд үйл ажиллагааны мөнгөн орлого 2,626.7 сая төгрөг, зарлага нь 2,170.4 сая төгрөг, үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ 456.3 сая төгрөг, улирлын эцсийн мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн үлдэгдэл 68.6 сая төгрөг байна. Санхүүгийн тайланг 2026 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр хүлээлгэн өгсөн.

2	Улирлын санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт	
	Аудитын хорооноос өгсөн дүгнэлт: Хангалттай	
3	Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт	
3.1	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	2026 оны 1-р улиралд түрээсийн орлого 2,387.9 сая төгрөг, зардал 2,085.7 сая төгрөг, 302.2 сая төгрөгийн ашигтай ажилласан байна. Ашиг өмнөх оны мөн үеэс 126.8 сая төгрөгөөр өссөн байна.
3.2	Хөрвөх чадвар боломжийн үзүүлэлт болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт	Төлбөрийн чадварын коэффициент 1.03 Нийт хөрөнгийн эргэлт 0.19 байна.
3.3	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл	2026 оны 1-р улиралд үйл ажиллагааны зардлыг бууруулан, хэвийн ажиллагааг хангаж ажиллалаа. Бараа бүтээгдхүүн, үйлчилгээний үнийн өсөлтөөс шалтгаалан ашиглалтын зардал өссөн байна. Цаашид түрээсийн орлогыг үе шаттай нэмэгдүүлэх, ашиглалтын зардлыг бууруулах, компанийн ашгийг нэмэгдүүлэхэд анхааран ажиллаж байна.
3.4	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого	Санхүүгийн тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил гүйлгээ байхгүй. Нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй.
4	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/	
	Тайлант хугацаанд компани Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийн 2026.03.13-ны өдрийн 26/05 дугаартай тогтоолын дагуу дараах сонирхлын зөрчилтэй хэлцлүүдийг хийсэн. Үүнд: 1. "НОМИН Тав Трейд" ХХК-тай Харуул хамгаалалтын үйлчилгээний гэрээ 2. "НОМИН Тав Трейд" ХХК-тай цэвэрлэгээ үйлчилгээний гэрээ 3. "НОМИН Трейдинг" ХХК-тай Лифтний засвар үйлчилгээний гэрээ 4. "Юнион ойл" ХХК-тай Цахилгаан эрчим хүчний засвар үйлчилгээний гэрээ 5. "НОМИН Мэйнтинэнс" ХХК-тай барилгын засвар үйлчилгээний гэрээ 6. "НОМИН Холдинг" ХХК-тай Мэдээллийн технологийн үйлчилгээний гэрээ 7. "НОМИН Холдинг" ХХК-тай Оффисын өрөө, суудлын түрээсийн гэрээ	
5	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл	
	Тайлант хугацаа компаниас хувьцаа нэмж гаргаагүй	
6	Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл	
	- Тайлант хугацаанд компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдаагүй. - Тайлант хугацаанд компанийн Төлөөлөн удирдах зөвлөл дараах шийдвэрүүдийг гаргасан. Үүнд: 1. 2026.01.13-нд Аудитын байгууллага сонгох тухай 26/01 дугаартай тогтоол гарсан. 2. 2026.02.12-нд Ногдол ашиг хуваарилах эсэх тухай 26/02 дугаартай тогтоол гарсан. 3. 2026.03.13-нд Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг дүгнэх тухай 26/03 дугаартай тогтоол гарсан. 4. 2026.03.13-нд Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал зарлан хуралдуулах тухай 26/04 дугаартай тогтоол гарсан. 5. 2026.13.13-нд Ашиглалтын үйлчилгээний гэрээ байгуулах тухай 26/05 дугаартай тогтоол гарсан. /ТУЗ-ийн хараат бус гишүүд/	

7	Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл	
	“Улсын их дэлгүүр” ХК-ийн зүгээс хувьцаа болон бусад төрлийн үнэт цаас нэмж гаргах, өрийг хувьцаагаар солих, компани хувьцаа эзэмшиж буй хувьцааг эргүүлэн худалдаж авах зэрэг үйл ажиллагаа явагдаагүй болно.	
Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:		
Овог, нэр: Х.Эрдэнэбаатар Албан тушаал: “Улсын их дэлгүүр” ХК-ийн гүйцэтгэх захирал Гарын үсэг: (Тамга/тэмдэг)		Овог, нэр: М.Өлзийбат Албан тушаал: “Улсын их дэлгүүр” ХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Гарын үсэг: (Тамга/тэмдэг)
Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:		
Овог, нэр: Д.Чимгээ Албан тушаал: Ахлах нягтлан бодогч Гарын үсэг:		

